

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 06

Улаангом хот

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт-гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8

Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна.

Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
---	--	--	--	--	--	--	--

1	Гадаадын иргэнд олгох Монгол Улсын визийн /цахим/ үйлчилгээг зохион байгуулах, гадаадын иргэний бүртгэл хяналтыг эрхлэх	Урсгал зардал	Гадаадын иргэнд Монгол Улсын виз болон бүртгэл хийж, хяналт тавьсан хувь.	-	Үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, холбогдох тоон үзүүлэлт гарсан байна.	Энэхүү хагас жилийн тайлант хугацаанд 3874 цахим визийн хүсэлтийг хүлээн авч хянан шалгаж, улмаар БНХАУ 3505, Тайвань 128, Энэтхэг 75, Гана 51, Вьетнам 14, Камбож 20, Мексик 13, Балба 19, Өмнөд Африк 7, , Колумб 4, Бруней 4, Мьянмар 3, Саудын араб 4, Индонез 2, Босни-Герцеговина 1, Маврики 3, Гватемал 1, Андорра 1, Ямайка 2, Габон 1, Уганда 1, Монтенегро 2, Кени 1, Гренада 1, Гондурас 2, Сент-Винсент-Гренади 1, Багамын арлууд 1, Зүүн тимор 1, Боливи 2 зэрэг 29 орны нийт 3870 гадаадын иргэнд цахим виз олгон шийдвэрлэн ажилласан. Үүнээс К2 ангиллын виз 3602, К4 ангиллын виз 62, К6 ангиллын виз 203 олгосон байна.	Энэ хугацаанд дараах шалтгаанаар БНХАУ-ын 3, Сьерра-Лион улсын 1 нийт 4 иргэнд виз олгохоос татгалзсан. Үүнд: БНХАУ-ын Шинжаань Уйгурын бүс нутгийн 2 иргэнд цахим виз олгохоос татгалзсан. /Нэг иргэний виз нь тагнуулын байгууллагын зөвшөөрөлгүй олгогдсон тул хүчингүй болгов/ Мөн БНХАУ-ын 1 иргэн МУ-аас албадан гаргасан хориг хугацаа дуусаагүй. Сьерра-Лион улсын нэг иргэн Гана улсын гэж худал мэдүүлсэн зэрэг шалтгаанаар татгалзсан болно.	Тайлант хугацаанд суралцах ангиллын оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан ОХУ-ын 4 иргэнд нөхөн хасалт хийсэн. Мөн уригч байгууллагын хүсэлтээр ОХУ-ын 2 иргэнийг хилээр гарах үед нь ОСЗөвшөөрөлд хасалт хийсэн. Мөн оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусаж буй ОХУ-ын 8 иргэн хилээр гарах үед нь	100
---	---	---------------	---	---	---	---	---	---	-----

					үнэмлэхийг нь хураан авсан. Боршоо хилийн боомтод визийн хугацааг цахимаар 15 хоногоор сунгуулсан ОХУ-ын 1 иргэний паспортад нөхөн бүртгэсэн хүртэл тэмдэг дарж хил нэвтрүүлсэн. Боршоо, Тэс боомтод нийт гадаадын иргэний хөдөлгөөнд ISM программ ашиглан хяналт тавьж ажилласан ба 02 сарын 09-ний өдрөөс ISM программ ажиллахгүй байгаа болно. Иймд өдөр тутмын мэдээг Боршоо, Тэс боомтын ШНАлбанаас авч өдөр бүр нэгтгэн мэдээлж байна. Хилийн боомтод хөтлөх дэвтрийг тогтмол хөтөлж, өдөр тутмын тайлан мэдээллийг оруулан ажиллаж байна. Боршоо автозамын боомтод энэ оны 05 сард гуравдагч орны буюу Киргизстан 3, Словак улсын 3 нийт 6 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан. Боршоо боомт нь 2 талын зорчигч /Орос, Монгол/ нэвтрүүлэх статустай ажиллаж байгаа дээрх иргэдийг буцаасан. Гадаад болон дотоодын иргэдэд энэхүү тайлант хугацаанд доорх төрлийн зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан байна. Үүнд: - Оршин суух зөвшөөрлийн сургалтын талаар 11, - Оршин суух зөвшөөрөл шинээр авах тухай 17, - Визийн сунгалтын тухай 45, - Зөрчил арилгуулах тухай 3, - Гадаад иргэний цахим бүртгэлийн тухай 85 зэрэг нийт 160 гаруй гадаад дотоодын иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр мөн дээрх чиглэлээр биечлэн 5 удаа, утсаар 6 удаа зөвлөгөө өгч ажилласан.	
2	Иргэдэд үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээллийг утсаар болон үйлчилгээний заалгаар дамжуулан үнэн зөв, шуурхай хүргэх.	Урсгал зардал	Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо:	-	Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай хүргэж, тоон үзүүлэлт гарсан байна.	95
3	Хариуцсан нутаг /Увс болон Завхан аймаг/ дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах.	Урсгал зардал	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь хувь:	-	Хяналт шалгалтыг зохион байгуулж, илрүүлэн шийдвэрлэсэн зөрчлийн тоон дүн үзүүлэлт	95

					/ХУБайцаагч Х.Адъяа/ Мөн энэ оны 05 сарын 02-ний өдөр "Улаангом политехник коллеж" сургуульд ажиллахаар /С2 ангилал/ ирсэн Солонгос улсын иргэн нь оршин суух зөвшөөрлийг хуульд заасан хугацаанд аваагүй 17 хоног хэтрүүлсэн зөрчилд, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид зааснаар 16.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.1-д заасны дагуу 170 нэгжээр буюу 170.000 /нэг зуун далан мянган/ төгрөгөөр торгох шийтгэлийн арга хэмжээ авсан. /ХУБайцаагч Д.Мырзабек/ ГНХГазрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Шашин, төрийн болон төрийн бус олон улсын байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарт хяналт шалгалт хийх" тухай ББ-2024/14-01 тоот удирдамжийн дагуу дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуйн нэгжид шалгалт хийсэн. Шалгалтыг Увс аймгийн төв Улаангом суманд шашин болон эрүүл мэнд боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 2 байгууллага аж ахуйн нэгжид Хэлтсийн дарга, ХУАБайцаагч Х.Адъяа, жолооч Б.Алтангэрэл нар энэ оны 03 дугаар сарын 21-ний өдөр явуулсан ба ямарваа нэг гадаад иргэн хамрагдаагүй болно. Энэхүү удирдамжийн хүрээнд Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр тухайн орон нутагт шалгалтыг зохион байгуулж, АНУ-ын 3 иргэн хамрагдаж, ямарваа нэг зөрчил илрээгүй болно. ГНХГазрын даргын 2024 оны 05 сарын 02-ний өдрийн дугаар 1-05/08 тоот төлөвлөгөөт шалгалт явуулах тухай удирдамжийн дагуу Увс аймгийн төв Улаангом болон Наранбулаг, Цагаанхайрхан сумын нутагт энэ оны 05 сарын 22-25-ны өдөр болон 31-ний өдрүүдэд хяналт шалгалт явуулж, 6 аж ахуйн нэгж байгууллага, тэр бүлийн шугмаар оршин суугч, түр ирэгч нийт 4 орны /БНСУ 1, Филиппин 1, Вьетнам 3, ОХУ 9/ 14 гадаадын иргэн хамрагдсан. Дээрх иргэдээс зөрчил гаргаж, арга хэмжээ авхуулсан гадаадын иргэн байхгүй. Увс аймгийн Хилийн 0245 болон 0311-р анги, аймгийн Цагдаагийн газар, Татнуулын газрын холбогдох ажилтанд 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөт
--	--	--	--	--	---

					ажиллагааны хурлыг энэ оны 01 сарын 28-ны өдөр албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж, холбогдох үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн хэлтсийн хурлыг энэ оны 03 болон 05 сард зохион байгуулж, цаг үеийн үйл ажиллагааны онцлог мэдээлэл, үүрэг даалгаврыг өгч ажиллав.		
					Тайлант хагас жилийн хугацаанд ГИХ-аарын дарга болон ББГ-аарын дарга бусад удирдах ажилтан тус хэлтсээс нийт 15 илтгэх хуудас боловсруулан танилцуулан шийдвэрлүүлж ажилласан. Албаны үйл ажиллагааны чиглэлээр нийт 11 төрлийн судалгаанд албан хаагчид хамрагдаж холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласан болно.		
					Хэлтсийн 2024 оны танилцуулгын зурган мэдээлэл тоо баримтыг шинэчлэн ажиллаж. Хэлтсийн 4 албан хаагч 2023 оны ХАСХОМэдүүлгийг хугацаанд нь гарган ЭБАТүшаалтанд мэдэгдэж баталгаажуулсан. 2024 оны 03 сарын 19-ний өдөр Хэлтсийн хурлыг зохион байгуулж, тус хэлтэст шинээр томилогдсон албан хаагч Х.Сувд-Эрдэнийг танилцуулан, албаны цаг үеийн болон Боршоо боомтод Х.Сувд-Эрдэнийг дэдлагажуулан ажиллах, цаашид хийх ажлын талаар болон анхаарах зүйлсийн талаар ярилцаж, холбогдох үүргийг өгч ажилласан.		
6	Төрийн байгууллагын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийг заавар журмын дагуу хийх.	Урсгал зардал	Архивын нэгжийн тоо, чанар;	-	Стандартын дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байдал, хүлээлтэн өгсөн тоо	Тус хэлтсийн албаны үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, албаны бичиг баримт, ирсэн явсан бичгийг нийт 3 хадгаламжийн нэгж болгон бэлтгэн хавтаслаж, Баруун бүс дэх газрын архивын ажилтанд хүлээлтэн өгсөн. Мөн 2024 оны Увс хэлтсийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад санал өгч ажиллав.	90
7	Хэлтэст ирсэн болон явсан албан бичигт бүртгэл хөтөлж, хариутай хугацаатай бичигт холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Урсгал зардал	Ирсэн, явсан албан бичгийн тоо, шийд-вэрлэлт;	-	Ирсэн бичгийг заасан хугацаанд нь шийдвэр-лэж, тухайн бүртгэлийг хөтөлж ажилласан байна.	Тайлант хугацаанд тус хэлтэст орон нутгийн засаг захиргааны байгууллага, хууль хүчний болон бусад байгууллагаас нийт 17 албан бичиг ирсэн ба үүнээс хариутай 5 бичгийг хугацаанд нь буцаан мэдээлж, албан тоот хүргүүлэн ажиллав. Увс аймаг дахь хэлтсээс дотоод албан бичиг 3 болон албан бичиг тоот /явсан бичиг/ нийт 13-ийг боловсруулан зохих байгууллагад хүргүүлэн ажилласан. Хилийн боомтын тухай хуулийн төсөлтэй танилцаж, холбогдох санал гарган ажилласан.	93

8	Иргэн, этгээдээс өргөдөл, хүсэлтийг хууль дагуу шийдвэрлэх.	хуулийн ирүүлсэн гомдол, холбогдох тогтоомжийн шуурхай	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь:	-	Өргөдөл гомдолойг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж ажилласан байх.	Энэхүү тайлант хугацаанд тус хэлтэст иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл гомдол ирээгүй болно. Хяналтын улсын байцаагч Д.Мырзабек Баан-Өлгий аймаг дахь хэлтэст шилжин ажиллах өргөдөл энэ оны 01 болон 04 сард гаргасныг хүлээн авч цохолт хийж, ББГазарт хүргүүлсэн. Энэхүү хатас жилийн хугацаанд жолооч Б.Алтангэрэл чөлөө хүссэн өргөдөл 1 удаа, ХУБайцаагч Д.Мырзабек чөлөө хүссэн өргөдөл 2 удаа, Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр чөлөө хүссэн өргөдөл 1 нийт 4 өргөдлийг хүлээн авч холбогдох чөлөө зөвшөөрлийг олгосон болно.	90
9	Дээд байгууллагаас орон нутгаас байгуулсан зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хаагчдыг хамруулах	шатны болон зохион сургалт, албан	Урсгал зардал	Сургалт зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчдийн тоо:	-	Өөрийн байгууллагын болон бусад газраас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байна.	Энэхүү тайлант хатас жилийн хугацаанд ГИХгазаас зохион байгуулсан цахим сургалт болон цахим хуралд нийт албан хаагчид нийт 12 удаа, ББГазраас зохион байгуулсан цахим хурал, сургалтад 6 удаа, төрийн албаны зөвлөгөөс зохион байгуулсан сургалтад 22 удаа нийт 40 гаруй удаагийн сургалт, цахим хурал зөвлөгөөнд албан хаагчид хамрагдсан болно. Дараах сургалт, хуралд биечлэн хамрагдсан. Үүнд: Хэлтсийн удирдлага Увс аймгийн тусгай чиг үүргийн болон төрийн цэргийн байгууллагуудын удирдлагуудын хуралд 2 удаа оролцсон. Боомтын захиргааны дарга Б.Батхшигт энэ оны 05 сарын 27-ний өдөр Боомтын захиргааны чиг үүрэг, төсөл хөтөлбөрийн өнөөгийн байдал" талаарх сургалтыг аймгийн ЗДТГгазарт зохион байгуулсан ба албан хаагчид оролцсон. ГИХгазрын даргын 2024 оны 03 сарын 07-ний өдрийн	92

					Б/65 тоот тушаалаар Х.Сувд-Эрдэнэ нь тус хэлтсийн мэргэжилтнээр шилжин /шинээр/ томилогдсон тул тухайн ажиглалтыг албанд дадлагажуулах төлөвлөгөө гаргаж, албаны үйл ажиллагааг танилцуулан, мэдээлэл заавар өгч чиглүүлэн, Боршоо авто замын боомтод энэ сарын 19-ний өдрөөс 30-ний өдөр хүртэл дадлагажуулан ажлуулав.	
10	Тэмдэгтийн хураамжийн торгуулийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, газрын санхүүд тайлагнан ажиллах.	Урсгал зардал	Төвлөрүүлсэн орлогын дүн, Тайлагнасан тоо,	-	Орлого хураамжийн хэмжээ, мөнгөн дүнг үнэн зөв мэдээлэн тайлагнах	Энэхүү тайлант хагас жилийн хугацаанд Увс аймгийн Тэс боомтод албан хаагчийн амьдрах байр барихад зориулан дэмжлэг үзүүлэн /орон нутгийн төсөвт/ Увс аймгийн Төрийн сангийн 100150000941 тоот Улсын тэмдэгтийн хураамжийн дансанд энэ оны 03 сарын байдлаар 331 сая төгрөгийг ГИХГазраас төвлөрүүлсэн. Энэ чиглэлээр Увс аймгийн ИТХурын шийдвэр гарч /16 тоот тогтоол/ нийт 90 сая төгрөгийг ГИХГазрын Увс хэлтсийг дэмжин, Тэс боомтод албан хаагчийн амьдрах байр болон албаны өрөөний засвар, автомашины засварын ажилд хуваарилан холбогдох тендер зарлагдан засварын ажил хийгдэж байна.
11	Тэс боомтод автозамын албан хаагчид амьдрах байр баруулах. /8х5,5 метр хэмжээтэй дөрвөн	Орон нутгийн төсөв	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь,	-	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь, явц байдлын тайлан	Энэ оны 02 сарын 13-ний өдөр манай хэлтсээс 2/06 тоот албан бичгээр Увс аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст Тэс автозамын боомтод баригдах албан хаагчийн амьдрах байр болон өрөөний засвар үйлчилгээ, авто машины

	улирлын сууц					засварын талаарх холбогдох мэдээлэл, техникийн нөхцөл, байр сууцны бүдүүвч зургийг гарган хүргүүлсэн. Мөн ажлын хүрээнд: Увс аймгийн Төрийн сангийн 100150000941 тоот Улсын тэмдэглэлийн хураамжийн дансанд энэ оны 03 сарын байдлаар 331 сая төгрөгийг ГИХГээрээс төвлөрүүлсэн.	85
12	Аймгийн төв Улаангом болон Боршоо боомтын ажлын байр, албаны авто машины иж бүрэн засвар үйлчилгээг хийх.	Орон нутгийн төсвөөр	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь,	-	Засварын ажлын явц, гүйцэтгэлийн хувь тайлагнал	Аймгийн төв Улаангом болон Боршоо боомтын өрөө, албаны автомашины засварын /30 сая төгрөг/ төндөр энэ оны 04 сарын 25-нд зарлагдаж /Увс ЗДТГ/ Эй-боди Зеро ХХК шалгасан. Иймд энэ оны 05 сарын 22-ны өдөр Увс аймгийн Байгаль орчны байгууллагын 2 давхарт байрлах 1 өрөөг засвар хийхэд зориулж чөлөөлж, засварын ажлыг эхлүүлээд байна. Мөн автомашиныг завсарын төндөрт сонгон шалгарсан дээрх компанид энэ оны 05 сарын 26-ны өдөр хүлээлгэн өгч засварын ажлыг тус тус хийж гүйцэтгэж байна. Мобисом компанийн Мобинет интернетийн сүлжээг, Улаангом хот дахь албаны өрөөнд 05 сарын 06-ны өдөр, Боршоо боомтод 05 сарын 16-ны өдөр, Тэс автозамын боомтод 05 сарын 30-ны өдөр тус тус холболтыг хийж дуусган интернетийн сүлжээнд бүрэн холбогдсон. Энэхүү сүлжээ холбох ажилд дэмжлэг үзүүлэн, Хил хамгаалах болон Гаалийн байгууллагын ажилтнуудтай холбогдож, хамтран ажилласан. Аймгийн төв Улаангом дахь албаны 2 өрөөг энэ хагас жилийн хугацаанд их цэвэрлэгээ /нойтон болон хуурай/ нийт 5 удаа хийж цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллав.	90
Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах							
13	"Нээлттэй өдөрлөг" байгуулах. /Улаангом	Урсгал зардал	Зохион байгуулалтын хувь,	-	Нээлттэй хаалганы өдөрлөг зохион	Энэ оны 05 сарын 01-ний өдөр Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа нэг цонхны үйлчилгээний цэгт "Хуульчийн пробоно нээлттэй хаалганы өдөрлөг"-г	

	сум болон боршоо боомт/			байгуулсан байна.	Шүүх, прокурор, татвар, нийгмийн даатгал, халамж, гадаадын иргэд харьяатын газар зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулсан. Уг өдөрлөгт ХУБайцаагч Д.Мырзабек, мэргэжилтэн Х.Сувд-Эрдэнэ нар оролцож, 20 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	
14	Гадаад иргэний оршин суух зөвшөөрөл, виз /цахим/ бүртгэл, гэрээ хэлэлцээрийн талаар /Шалгатч нарт/ сургалт зохион байгуулах.	Урсгал зардал	Сургалт явуулсан тоо, хамрагдсан албан хаагчид;	-	Сургалт зохион байгуулм, мэдээлэл хүргэсэн байна.	

Хэсгийн дундаж хувь:
Нийт үнэлгээ:

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэдлэг, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	
		Хүрсэн түвшин / Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4
"Төрийн албаны тухай хууль, салбарын тухай хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх" зорилтын хүрээнд			

1	Арга хэмжээ 1. Хууль эрх зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх	Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Зөрчлийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмуудыг цаг тухай бүр судалж ажилласан. ГИХ-аараас болон Төрийн албаны зөвлөл, Баруун бүсийн газраас зохион байгуулсан сургалтанд тогтмол хамрагдаж ирсэн.	95
2	Арга хэмжээ 2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	"Монгол бичиг"-ийн суурь мэдлэгээ бататгаж, Монгол бичгээр гарсан ном, сонин унших болон "Монгол бичиг" цахим олон нийтийн мэдээллийн сүлжээнд нэгдэж нийтэлсэн мэдээлэл уншиж, өдөр бүр бусдаас суралцаж, унших чадвар хурд сайжирч, дээшилж байна.	90
3	Арга хэмжээ 3. Гадаад хэлний мэдлэг, ярих, бичих чадвараа дээшлүүлэх	Хэлтсийн дарга Х.Адьяа мний бие энэ оны 05 сарын 04-ний өдөр Улаанбаатар хотод Дезерет Олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Англи хэлний заах арга зүйн" сургалт семинарт хамрагдсан. Англи хэл болон Орос хэлийг чөлөөт цагаараа бие дааж, үзэж суралцаж байна. Мөн интернет болон цахим орчинд хэлний мэдлэгээ дээшлүүлэх бичлэг, мэдээ мэдээллийг ашиглан хэл судалж байна.	90

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:
БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН ДАРГА

2024 оны 06 сарын 13 өдөр

А.ХУАНБАЙ

ТАЙЛАГНАСАН:
УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН ДАРГА

2024 оны 06 сарын 06 өдөр

Х.АДЬЯА



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 05

Улаангом хот

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт-гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна.							
Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
1	Гадаадын иргэнд олгох Монгол Улсын визийн /цахим/ үйлчилгээг зохион байгуулах, гадаадын иргэний бүртгэл хяналтыг эрхлэх	Урсгал зардал	Гадаадын иргэнд Монгол Улсын виз болон бүртгэл хийж, хяналт тавьсан хувь:	100	Үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, холбогдох тоон үзүүлэлт гарсан байна.	Энэхүү тайлант бүтэн жилийн хугацаанд 12284 цахим визийн хүсэлтийг хүлээн авч хянан шалгаж, улмаар БНХАУ 11054, Тайвань 467, Энэтхэг 302, БНСУ 151, Гана 51, Камбож 38, Балба 27, Мексик 25, Өмнөд Африк 24, Колумб 19, Вьетнам 14, Саудын араб 12, Мьянмар 11, Маврики 9, Монтенегро 5, Бруней 4, Босни-Герцеговина 3, Коста-рика 3, Индонез 2, Гренада 2, Гондурас 2, Ямайка 2, Бутан 2, Боливи 2, Сент-Китс ба Невис 2, Кувейт 2, Сент-Винсент-Гренади 1, Багамын арлууд 1, Зүүн тимор 1, Габон 1, Уганда 1, Кени 1, Гватемал 1, Андорра 1, Фижиг 1, Папуа-Шинэ Гвиней 1, Гонконг 1, Доминика 1, Мавритан 1, Панама 1, Сент-Лисия 1, Тувалу 1 зэрэг 42 орны нийт 12251 гадаадын иргэнд цахим виз олгон шийдвэрлэн ажилласан. Үүнээс К2 ангиллын виз 11339, К4 ангиллын виз 292, К6 ангиллын виз 620 тус тус олгосон байна. Энэхүү визийн нийт орлогын мөнгөн дүн нь 1 тэрбум 930 гаруй сая төгрөг болж байна.	76

					хориглосон зэрэг үндэслэлээр виз олгохоос татгалзсан. Тайлант хугацаанд суралцах ангиллын оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан ОХУ-ын 9 иргэнд нөхөн хасалт хийсэн. Мөн уригч байгууллагын хүсэлтээр ОХУ-ын 8 иргэнийг хилээр гарах үед нь ОСЗөвшөөрөлд хасалт хийсэн. Оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусаж буй ОХУ-ын 13 иргэн хилээр гарах үед нь ОСЗ-ийн үнэмлэхийг нь хураан авсан. Боршоо хилийн боомтод визийн хугацааг цахимаар сунгуулсан ОХУ-ын 3 иргэний паспортад нөхөн бүртгэсэн хүртэл тэмдэг дарж хил нэвтрүүлсэн. Боршоо, Тэс боомтод нийт гадаадын иргэний хөдөлгөөнд ISM программ ашиглан хяналт тавьж ажилласан ба 02 сарын 09-ний өдрөөс ISM программ ажиллахгүй байгаа болно. Иймд өдөр тутмын мэдээг Боршоо, Тэс боомтын ШНАЛбанаас авч өдөр бүр нэгтгэн мэдээлж байна. Хилийн боомтод хөтлөх дэвтрийг тогтмол хөтөлж, өдөр тутмын тайлан мэдээллийг оруулан ажиллаж байна. Энэхүү тайлант хугацаанд дээрх 2 хилийн боомтоор зорчиж буй ОХУ-ын 75,000 гаруй иргэний бичиг баримтад хяналт тавьж ажилласан байна. Боршоо автозамын боомтод энэ оны 05 сард гуравдагч орны буюу Киргизстан 3, Словак улсын 3 нийт 6 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан. Боршоо боомт нь 2 талын зорчигч /Орос, Монгол/ нэвтрүүлэх статустай ажилладаг тул дээрх иргэдийг нэвтрүүлэлгүй буцаасан болно.
2	Иргэдэд үйлчилгээний талаарх мэдээллийг болон үйлчилгээний заалаар дамжуулан үнэн зөв, шуурхай хүргэх.	Урсгал зардал	Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо:	100	Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу түргэн шуурхай хүргэж, тоон үзүүлэлт гарсан байна.
					Гадаад болон дотоодын иргэдэд энэхүү тайлант хугацаанд доорх төрлийн зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан байна. Үүнд: - Оршин суух зөвшөөрлийн сунгалтын талаар 21, - Оршин суух зөвшөөрөл шинээр авах тухай 31, - Визийн сунгалтын тухай 58, - Зөрчил арилгуулах тухай 7, - Гадаад иргэний цахим бүртгэлийн тухай 203 зэрэг нийт 320 гадаад дотоодын иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр мөн дээрх чиглэлээр биечлэн 23 удаа, утсаар 13 удаа

885

3	Хариуцсан нутаг /Увс болон Завхан аймаг/ дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах.	Урсгал зардал	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь хувь:	100	Хяналт шалгалтыг зохион байгуулж, илрүүлэн шийдвэрлэсэн зөрчлийн тоон дүн үзүүлэлт	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг ГИХГазрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 03 сарын 19-ний өдрийн ББ-2024/14-01 тоот удирдамж, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1-05/08 тоот удирдамж, 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1-05/11 дугаарт, 2024 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн ББ-2024/14-07 дугаарт, 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн ББ-2024/14-09 дугаарт удирдамжуудаар 5 удаа зохион байгуулсан. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 02 өдрийн ББ-2024/14-04 дугаарт, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн ББ-2024/14-08 дугаарт, 2024 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн ББ-2024/14-08 дугаарт удирдамжаар 3 удаа зохион байгуулсан. Энэхүү нийт 8 удаагийн шалгалтад 9 аж ахуй нэгж байгууллагад ажиллаж хөдөлмөрлөж буй гадаадын 7 орны /ОХУ, БНСУ, БНСВУ, БНХАУ Тажикстан, Герман, Филиппин/ 53 иргэн хамрагдсан байна. Шалгалтаар Увс аймагт БНХАУ-ын 7 иргэний зөрчил, Завхан аймагт БНХАУ-ын 15 иргэний зөрчил нийт 22 иргэний зөрчлийг тус тус илрүүлэн хуулийн дагуу шалган шийдвэрлэсэн. Энэхүү тайлант хугацаанд тус хэлтэс Увс аймагт 12 зөрчлийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн. Үүнд: 2 /Филиппин иргэн/ торгуулийн арга хэмжээ, /БНСУ-ын иргэн/ 1 торгуулийн арга хэмжээ авч, БНХАУ-ын 7 иргэн /албадан гаргасан/, ОХУ-ын 2 иргэнд тус тус зөрчлийн арга хэмжээ авсан. Мөн тайлант хугацаанд Завхан аймагт БНХАУ-ын 15 иргэнд зөрчлийн арга хэмжээ авсанаас, 14 иргэнийг албадан гаргасан байна. Торгуулийн нийт дүн нь Увс аймагт 1,860,000 /төрийн санд/ Завхан аймагт 1,680,000 буюу нийт 3,540,000 төгрөгийг төвлөрүүлсэн. Увс аймгийн Хилийн 0245 болон 0311-р анги, аймгийн
						2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөг /төсөл/ хургуулж, улмаар ББГазартай хамтран ажиллах

						төлөвлөгөөг батлуулан ажиллав.
						Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 1-05/12 тоот удирдамжид заасны дагуу НЗ /хувийн хэргээр оршин суух/ ангиллаар оршин суух зөвшөөрөл хүссэн, ОХУ-ын иргэн болон энэ оны 1-05/19 тоот удирдамжаар ОХУ-ын иргэн гэрт хяналт шалгалт хийж, оршин суух зөвшөөрөл /F-1/ олгох эсэх чиглэлээр байцаагчийн дүгнэлт үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. /ХУБайцаагч Д.Мырзабек болон ХУАБайцаагч Х.Адьяа/
						Монгол Улсаас 2018 онд албадан гаргагдаж байсан, орохыг хориглосон хугацаа нь дуусаагүй ОХУ-ын иргэн , 2024 оны 01 сард хил нэвтрэх гэж ирэх үед илрүүлж, ISM-ийн сүлжээний Хяналт, шалгалтын хэсгийн буцаалтын цонхонд бүртгэж, бичиг баримтыг нь хуулбарлаж, тухайн гадаадын иргэнтэй ярилцлага хийж хил нэвтрүүлэхгүйгээр буцаасан.
						ГИХГазрын төвөөс албадан гаргасан ОХУ-ын иргэн энэ оны 01 сард хилээр гарах үед хяналт тавьж, гадаадын иргэнийг "Монгол Улсаас албадан гаргасан тухай тодорхойлолт" үйлдэж ГИХГазрын хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.
						Завхан аймагт энэ оны 05 сарын 02-09-ний өдөр нийт 2 удаа 3 хоног ажиллаж, энэ хугацаанд Улиастай хотод хууль бусаар оршин сууж буй Австри улсын 2 иргэн албадан гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэн Хэлтсийн дарга Х.Адьяа, Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр, Жолооч Б.Алтангэрэл нарын хамт ажиллаж
						шалгалтын газрын холоогдох байцаагч ажиллагаа явуулж, шүүгчийн захирамжаар саатуулах ажиллагааг хийсэн. Энэ талаар ББГазрын даргад илтгэх хуудсаар танилцуулан ажилласан.
						Увс аймгийн Улаангом сумын 7-р багт Вьетнам засварын үйл ажиллагаа явуулдаг
						ХУБайцаагч Д.Мырзабек байцаагчийн албан шаардлага

						хүргүүлэн, зөрчлийг /хаягийн/ арилгуулан ажилласан. 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн ББГ-18/095-04 дугаартай дүгнэлт /Х.Сувд-Эрдэнэ/ үйлдэж, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/360 тушаалаар БНХАУ-ын 7 иргэнийг 3 жилийн хугацаатай Монгол Улсад орох эрхгүйгээр, 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Замын-Үүд Олон улсын боомтод ХУБайцагч Д.Мырзабек биечлэн хүргэж, Монгол Улсаас албадан гаргасан. Завхан аймаг дахь ХУБайцагч Г.Хишигдэлгэр энэ оны 07 болон 11-р сард БНХАУ-ын нийт 14 иргэний зөрчлийг шалгалтаар илрүүлэн зөрчлийн арга хэмжээг авч, албадан гаргах тухай дүгнэлт үйлдэж, Буян-Ухаа болон Замын-Үүд боомтоор тус тус албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ тайлант хугацаанд Увс аймаг дахь хэлтсээс БНХАУ-ын нийт 21 иргэнийг албадан гаргасан болно.
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.						
5	Албаны үйл ажиллагааны чиглэлээр холбогдох судалгаа, илтгэх хуудас, төлөвлөгөө тайланг гарган, Газрын холбогдох нэгж удирдлагад мэдээлэх	Урсгал зардал	Боловсруулсан баримт бичгийн тоо	100	Хэлтсийн боловсруулсан баримт бичиг болон холбогдох нэгжид хүргүүлсэн тоон дүн	Увс аймаг дахь хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, Баруун бүс газрын Захиргааны ахлах мэргэжилтэн Ц.Одгэрэлд хүргүүлэн, батлуулж ажилласан. Мөн Увс аймаг дахь хэлтсийн Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр, ХУБайцагч Д.Мырзабек, мэргэжилтэн Сувд-Эрдэнэ нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүлээн авч, хянаж, баталгаажуулж ажиллав. Увс аймаг дахь хэлтсийн 2024 оны албаны үйл ажиллагааны хурлыг энэ оны 01 сарын 28-ны өдөр албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж, холбогдох үүрэг даалгаврыг өгч ажилласан. Мөн тус хэлтсийн хурлыг энэ оны 03 болон 06, 10 сард нийт 4 удаа зохион байгуулж, цаг үеийн үйл ажиллагааны онцлог мэдээлэл, үүрэг даалгаврыг өгч, холбогдох чиглэлийг өгч ажиллав. Тайлант бүтэн жилийн хугацаанд ГИХГазрын дарга

87

						болон ББГазрын дарга бусад удирдах ажилтанд тус хэлтсээс нийт 28 илтгэх хуудас боловсруулан танилцуулан шийдвэрлүүлж ажилласан. Албаны үйл ажиллагааны чиглэлээр нийт 18 төрлийн судалгаанд албан хаагчид хамрагдаж холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласан болно.
						Хэлтсийн 2024 оны танилцуулгын зурган мэдээлэл тоо баримтыг 3 удаа шинэчлэн ажиллав. Хэлтсийн 4 албан хаагч 2023 оны ХАСХОМэдүүлгийг хугацаанд нь гарган ЭБАТушаалтанд мэдэгдэж баталгаажуулсан. Тайлант хугацаанд Монгол Улсын хууль тогтоомж болон ГИХГазрын даргын шинээр батлагдсан, албан үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар зэргийг хэвлэн, ангилан төрөлжүүлж хавтаслаж ажилласан.
						2024 оны 03 сарын 19-ний өдөр Хэлтсийн хурлыг зохион байгуулж, тус хэлтэст шинээр томилогдсон албан хаагч Х.Сувд-Эрдэнийг танилцуулан, албаны цаг үеийн болон Боршоо боомтод Х.Сувд-Эрдэнийг дадлагажуулан ажиллах, цаашид хийх ажлын талаар болон анхаарах зүйлсийн талаар ярилцаж, холбогдох үүргийг өгч ажилласан. Хяналтын Прокуророос өгсөн чиглэлийн дагуу зөрчлийн хэргийн дэвтрийг шинэчлэн гаргасан.
6	Төрийн байгууллагын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийг заавар журмын дагуу хийх.	Урсгал зардал	Архивын нэгжийн тоо, чанар;	100	Стандартын дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байдал, хүлээлгэн өгсөн тоо	Тус хэлтсийн 2023 оны албаны үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, албаны бичиг баримт, ирсэн явсан бичгийг нийт 3 хадгаламжийн нэгж болгон бэлтгэн хавтаслаж, Баруун бүс дэх газрын архивын ажилтанд хүлээлгэн өгсөн. Мөн 2024 оны Увс хэлтсийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад санал өгч ажиллав.
7	Хэлтэст ирсэн болон явсан албан бичигт бүртгэл хөтөлж, хариутай хугацаатай бичигт холбогдох арга хэмжээг авч ажиллах.	Урсгал зардал	Ирсэн, явсан албан бичгийн тоо, шийд-вэрлэлт;	100	Ирсэн бичгийг заасан хугацаанд нь шийдвэрлэж, тухайн бүртгэлийг хөтөлж ажилласан байна.	Тайлант хугацаанд тус хэлтэст орон нутгийн засаг захиргааны байгууллага, хууль хүчний болон бусад байгууллагаас нийт 24 албан бичиг ирсэн ба үүнээс хариутай 9 бичгийг хугацаанд нь буцаан мэдээлж, албан тоот хүргүүлэн ажиллав. Хугацаа хожимдуулсан албан тоот бичиг байхгүй болно.
						Увс аймаг дахь хэлтсээс дотоод албан бичиг 4, албан бичиг тоот /явсан бичиг/ нийт 29-ийг боловсруулан зохих байгууллагад хүргүүлэн ажилласан. Хилийн боомтын тухай хуулийн төсөлтэй танилцаж холбогдох санал

					гарган ажилласан.	
8	Иргэн, этгээдээс өргөдөл, хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь;	100	Өргөдөл гомдолойг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж ажилласан байх.	Энэхүү тайлант хугацаанд тус хэлтэст иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл гомдол ирээгүй болно. Хяналтын улсын байцаагч Д.Мырзабек Баян-Өлгий аймаг дахь хэлтэст шилжин ажиллах өргөдөл энэ оны 01 болон 04 сард гаргасныг хүлээн авч цохолт хийж, ББГазарт хүргүүлсэн. Энэхүү тайлант жилийн хугацаанд жолооч Б.Алтангэрэл чөлөө хүссэн өргөдөл 2 удаа, ХУБайцаагч Д.Мырзабек чөлөө хүссэн өргөдөл 5 удаа, Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр чөлөө хүссэн өргөдөл 2 нийт 9 өргөдлийг хүлээн авч холбогдох чөлөө зөвшөөрлийг олгож шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд хэлтсийн удирдлага Боршоо боомтын зөвлөлийн хуралд 5 удаа, ГИХГазрын даргын тушаалаар байгууллагын "Удирдах ажилтны цугларалт"-д энэ оны 01 сард УБ хотод хамрагдсан. Мөн энэ оны 11 сарын 14-ний өдөр ГИХГазрын "Бодлогын судалгааны зөвлөл" байгуулах талаар анханы хурал зөвлөгөөнд оролцсон. Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр Улаанбаатар хотод ГИХГазар дээр энэ оны 02 сарын 26-аас 03 сарын 01-ний өдөр хүртэл Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ болон цахим систем, Сайрго үйлчилгээний талаарх сургалтад суусан. Мөн тус хэлтэст шинээр томилогдсон мэргэжилтэн Х.Сувд-Эрдэнэ энэ оны 05 сарын 13-17-ний өдрүүдэд ГИХГазар дээр чиглүүлэх сургалт болон энэ оны 10-р сард Хяналтын улсын байцаагчийн сургалтад тус тус хамрагдсан. ХУБайцаагч Х.Сувд-Эрдэнэ Газрын даргын тушаалаар энэ оны 10 сарын 28-аас 12 сарын 07-ны өдөр хүртэл ГИХГазрын төв дээр сэлгэн ажиллаж, дадлагжин мэргэшиж байна. Энэхүү тайлант жилийн хугацаанд ГИХГазраас зохион байгуулсан цахим сургалт болон цахим хуралд нийт албан хаагчид 23 удаа, ББГазраас зохион байгуулсан цахим хурал, сургалтад 14 удаа, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 31 удаа нийт 70 гаруй удаагийн сургалт, цахим хурал зөвлөгөөнд албан хаагчид хамрагдсан болно. Дараах сургалт, хуралд биечлэн хамрагдсан. Үүнд:
9	Дээд байгууллагаас орон нутгаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт албан хаагчдыг хамруулах	Урсгал зардал	Сургалт зөвлөлгөөнд хамрагдсан албан хаагчдийн тоо;	100	Өөрийн байгууллагын болон бусад газраас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байна.	Энэхүү тайлант жилийн хугацаанд ГИХГазар дээр энэ оны 02 сарын 26-аас 03 сарын 01-ний өдөр хүртэл Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ болон цахим систем, Сайрго үйлчилгээний талаарх сургалтад суусан. Мөн тус хэлтэст шинээр томилогдсон мэргэжилтэн Х.Сувд-Эрдэнэ энэ оны 05 сарын 13-17-ний өдрүүдэд ГИХГазар дээр чиглүүлэх сургалт болон энэ оны 10-р сард Хяналтын улсын байцаагчийн сургалтад тус тус хамрагдсан. ХУБайцаагч Х.Сувд-Эрдэнэ Газрын даргын тушаалаар энэ оны 10 сарын 28-аас 12 сарын 07-ны өдөр хүртэл ГИХГазрын төв дээр сэлгэн ажиллаж, дадлагжин мэргэшиж байна.

					Хэлтсийн удирдлага Увс аймгийн тусгай чиг үүргийн болон төрийн цэргийн байгууллагуудын удирдлагуудын хуралд 2 удаа оролцсон. Боомтын захиргааны дарга Б.Батхшиг энэ оны 05 сарын 27-ний өдөр Боомтын захиргааны чиг үүрэг, төсөл хөтөлбөрийн өнөөгийн байдал” талаарх сургалтыг аймгийн ЗДТГазарт зохион байгуулсан ба албан хаагчид оролцсон. ГИХГазрын даргын 2024 оны 03 сарын 07-ний өдрийн Б/65 тоот тушаалаар Х.Сувд-Эрдэнэ нь тус хэлтсийн мэргэжилтнээр шилжин /шинээр/ томилогдсон тул тухайн ажилтныг албанд дадлагажуулах төлөвлөгөө гаргаж, албаны үйл ажиллагааг танилцуулан, мэдээлэл заавар өгч чиглүүлэн, Боршоо авто замын боомтод энэ сарын 19-ний өдрөөс 30-ний өдөр хүртэл дадлагажуулан ажлуулав. Тероризмтэй тэмцэх зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн гишүүн байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан “Хаан шонхор-2024” сэдэвт танхимын сургалтад 2024.09.18 болон 2024.09.20, 2024.09.24-25-ны өдрүүдэд хэлтсийн 2 албан хаагч танхимаар хамрагдаж, 2024.09.27-ны өдөр Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудалд үзүүлэх сургалтад биечлэн хамрагдсан.
10	Тэмдэгтийн хураамжийн орлого, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, Бүсийн газрын санхүүд тайлагнан ажиллах.	Урсгал зардал	Төвлөрүүлсэн орлогын дүн, Тайлагнасан тоо;	100	Орлого хураамжийн хэмжээ, мөнгөн дүнг үнэн зөв мэдээлэн тайлагнах
					Энэхүү тайлант хагас жилийн хугацаанд Увс аймгийн төрийн сангийн 100150000955 тоот дансанд гадаадын 12 иргэн, түүний харьяалах ААН байгууллагын зөрчлийн торгуулийн дүн болох 1,860,000 төгрөгийг төвлөрүүлсэн.
					ГИХГазрын 2024 оны төлөвлөгөөнд тусгасан ажил болох Тэс боомтод албан хаагчийн амьдрах байр барихад зориулан дэмжлэг үзүүлэн /орон нутгийн төсөвт/ Увс аймгийн Төрийн сангийн 100150000941 тоот Улсын тэмдэгтийн хураамжийн дансанд энэ оны 03 сарын байдлаар 331 сая төгрөгийг ГИХГазраас төвлөрүүлсэн. Энэ чиглэлээр Увс аймгийн ИТХурлын шийдвэр гарч /16 тоот тогтоол/ нийт 90 сая төгрөгийг ГИХГазрын Увс хэлтсийг дэмжин, албаны өрөөний засвар, автомашины засварын ажил /30 сая төгрөг/ Эй-Боди Зеро ХХК шалгарч ажлыг хийж гүйцэтгэсэн. Тэс боомтод албан хаагчийн амьдрах байр барих /60 сая/ зарлагдаад ажил

828

					сонгон шалгаруулалт явагдаж байна. /Гүйцэтгэгч ААН тодроогүй/	
	ББГазрын дарга А.Хуанбайд "Хэлтэст тулгамдаж буй санхүүгийн төлбөр тооцоог шийдвэрлэх тухай" илтгэх хуудас энэ оны 02 сарын 20-ны өдөр бэлтгэн хүргүүлсэн. Тухайн хэлтсийн харьяа байр өрөөний дулаан цахилгааны төлбөр болон түрээстэй холбоотой гарч буй зардлыг танилцуулан, хэрхэн шийдвэрлэх талаар хамтран зөвшилцөж ажиллаж, Улаангом дахь албаны өрөөний 2023-2024 оны дулааны төлбөр зардлыг шийдвэрлүүлэхэд анхаарч БОАЖГазрын дарга Г.Энхтуяа уулзаж, 180,000 төгрөгийн хог хаягдлын зардлыг төлөх байдлаар, хоёр жилийн түрээсийн төлбөрийг бүрэн барагдуулсан.				Тэс боомтод барилга барих газрын гэрчилгээг энэ оны 07 сарын 24-ний өдөр шинээр дахин /өмнөх газар нь тусгай хамгаалалтын бүсэд орсон/ гаргуулсан. 2016 онд манай байгууллагад олгосон тухайн газрын байршлаас 200 метр зайд, өөр байршилд /тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн заагаас гаргаж/ шилжүүлэн авсан.	
11	Тэс авто замын боомтод баригдах барилгын зургыг Барилгын инженерүүд ХХК-аар гүйцэтгүүлэн, 2024 оны 09 сард бэлэн болгож, бусад холбогдох техникийн нөхцөлийг авч энэ оны 09 сарын 26-ны өдрөөс хойш нийт 6 удаа тендер шалгаруулалт зарлаад буй бөгөөд энэхүү 60 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилгын гүйцэтгэлд орох ААН одоогоор тодроогүй байна. Энэхүү барилгын нийт төсөвт өртөг нь 97 сая төгрөг болсон бөгөөд иймд энэ онд гүйцэтгэх ажлыг хувааж 60 сая төгрөгийн үнийн дүн бүхий ажилд гүйцэтгэгч сонгон шалгаруулалт явуулж байна.	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь, явц байдлын тайлан	100	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь;	Орон нутгийн төсөв	Тэс автозамын боомтод албан хаагчид амьдрах байр бариулах. /8х5,5 метр хэмжээтэй дөрвөн улирлын сууц/
12	Аймгийн төв Улаангом болон Боршоо боомтын ажлын байр, албаны авто машины иж бүрэн засвар үйлчилгээг хийх.	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь тайлагнал	100	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь;	Орон нутгийн төсвөөр	

					Засаг даргын А/369 тоот захирамжийн дагуу тендерийн ажил хүлээн авах комисс ажиллаж, ажлын гүйцэтгэлийг үнэлж хүлээн авч, улмаар тухайн өрөөнд нүүж орж, шинээр хоёр самбар, хөшиг зэргийг тогтоож тохижилт ажил хийсэн. Ийнхүү албаны автомашинд засвар үйлчилгээ хийлгэж мөн ажил үүргээ гүйцэтгэх тохилог орчин бүрдсэн болно. Mobisom компанийн Мобинет интернетийн сүлжээг, Улаангом хот дахь албаны өрөөнд 05 сарын 06-ны өдөр, Боршоо боомтод 05 сарын 16-ны өдөр, Тэс автозамын боомтод 05 сарын 30-ны өдөр тус тус холболтыг хийж дуусган интернетийн сүлжээнд бүрэн холбогдсон. Аймгийн төв Улаангом дахь албаны 2 өрөөг энэ хагас жилийн хугацаанд их цэвэрлэгээ /нойтон болон хуурай/ нийт 14 удаа хийж цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллав. 2024 оны 06 сарын 24-ний өдөр хэлтсийн дарга Х.Адъяа, жолооч Б.Алтангэрэл нар Боршоо боомтын албан өрөөнд мэдээллийн 2 ш самбар, ширээ 1 ш, сандал 2 ш зэргийг хүргэж албаны өрөөг тохижуулсан. Үйлчилгээний нэгдсэн төв дэх албаны өрөө тасалгааны хаягийг сольж шинэчилсэн.
Зорилт 3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах					
13	"Нээлттэй өдөрлөг" байгуулах. /Улаангом сум болон Боршоо боомт/	Урсгал зардал	Зохион байгуулалтын хувь;	100	Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна. Энэ оны 05 сарын 01-ний өдөр Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа нэг цонхны үйлчилгээний цэгт "Хуульчийн пробоно нээлттэй хаалганы өдөрлөг"-т Шүүх, прокурор, татвар, нийгмийн даатгал, халамж, гадаадын иргэд харьяатын газар зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулсан. Уг өдөрлөгт ХУБайцаагч Д.Мырзабек, мэргэжилтэн Х.Сувд-Эрдэнэ нар оролцож, 20 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Боршоо боомтод нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээ зохион байгуулаагүй болно. Боршоо боомтын шинэ цогцолборын нээлт 2024 оны 04 сарын 06-ны өдөр болсон ба уг үйл ажиллагаанд хэлтсийн дарга Х.Адъяа болон хяналтын улсын байцаагч Д.Мырзабек, жолооч Б.Алтангэрэл нар оролцсон. Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын 3 дугаар байрны "Хурдан" үйлчилгээний төвийн 16 тоот

					өрөөнд байрлах албаны үйл ажиллагааг сурталчилсан 3 самбарын мэдээллийг шинэчилсэн.
					2024 оны 05 сарын 21-ний өдөр тус хэлтэс нь аймгийн Цагдаа болон Тагнуулын байгууллагатай хамтран Зочид буудлын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан уулзалт хурлыг зохион байгуулж, гадаад иргэдийн чиглэлээр мэдээлэл хүргэж, харилцан мэдээлэл солилцох Viber группыг нээж, өдөр бүр мэдээлэл солилцож, зочид буудалд байрлаж буй гадаад иргэдэд хяналт тавьж ажиллаж байна. Энэ уулзалтад нийт 16 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Энэхүү уулзалт хурлыг Увс аймгийн Цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгч, ахлах дэслэгч Б.Хүрэлсайхан, тус аймгийн Тагнуулын газрын ажилтан, ахлах дэслэгч Э.Билгүүн болон хэлтсийн албан хаагчид хамтран аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хурлын танхимд зохион байгуулсан.
					Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжоор 15 нүүр слайд бүхий сургалтын хичээл бэлтгэж энэ оны 08 сарын 02-ны өдөр Боршоо авто замын боомтод Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар Хилийн шалган нэвтрүүлэх албаны 11 ажилтанд сургалт зохион байгуулсан. /Хэлтсийн дарга Х.Адьяа/ Мөн ХУБайцаагч Д.Мырзабек энэ оны 12 сарын 01-ний өдөр Боршоо боомтын ШНАлбаны 9 ажилтанд оршин суух зөвшөөрөл, виз бүртгэлийн чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн Завхан аймаг дахь ахлах мэргэжилтэн Г.Хишигдэлгэр Арцсуурь боомтын ШНАлбаны 5 ажилтанд ГИЗЭБТухай хуулиар энэ оны 08 сард холбогдох сургалтыг зохион байгуулсан.
14	Гадаад иргэний оршин суух зөвшөөрөл, виз /цахим/ бүртгэл, гэрээ хэлэлцээрийн талаар /Шалгагч нарт/ сургалт зохион байгуулах.	Урсгал зардал	Сургалт явуулсан тоо, хамрагдсан албан хаагчид;	100	Сургалт зохион байгуулж, мэдээлэл хүргэсэн байна.

Хэсгийн дундаж хувь:

Нийт үнэлгээ:

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт Хүрсэн түвшин / биелэлт	Гүйцэтгэл-
-----	---	--	------------

		3		ийн хувь
				4
"Төрийн албаны тухай хууль, салбарын тухай хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх" зорилтын хүрээнд				
1	Арга хэмжээ 1. Хууль эрх зүйн мэдлэг, чадвараа дээшлүүлэх	Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Зөрчлийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмуудыг цаг тухай бүр судалж ажилласан. ГИХГазраас болон Төрийн албаны зөвлөл, Баруун бүсийн газраас зохион байгуулсан 40 гаруй цагийн сургалтанд нийтдээ 28 удаа хамрагдсан.	82	
2	Арга хэмжээ 2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	"Монгол бичиг"-ийн суурь мэдлэгээ бататгаж, Монгол бичгээр гарсан ном, сонин унших болон "Монгол бичиг" цахим олон нийтийн мэдээллийн сүлжээнд нэгдэж нийтэлсэн мэдээлэл уншиж, өдөр бүр бусдаас суралцаж, унших чадвар хурд сайжирч, дээшилж байна. Удирдлагын академээс зохион байгуулж буй Монгол бичгийн анхан шатны 40 цагийн сургалтанд цахимаар хамрагдаж, сертификат авсан.	82	
3	Арга хэмжээ 3. Гадаад хэлний мэдлэг, ярих, бичих чадвараа дээшлүүлэх	Хэлтсийн дарга Х.Адъяа мний бие энэ оны 05 сарын 04-ний өдөр Улаанбаатар хотод Дезерет Олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Англи хэлний заах арга зүйн" сургалт семинарт хамрагдсан. Англи хэл болон Орос хэлийг чөлөөт цагаараа бие дааж, үзэж суралцаж байна. Мөн интернет болон цахим орчинд хэлний мэдлэгээ дээшлүүлэх бичлэг, мэдээ мэдээллийг ашиглан хэл судалж байна.	82	

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:
БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН ДАРГА

2024 оны 12 сарын 04 өдөр

3.БАТСҮЛД

ТАЙЛАГНАСАН:
УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН ДАРГА

2024 оны 12 сарын 05 өдөр

Х.АДЪЯА

ХТ07570 4081676